



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 7/202

Мандалговь

Г 7
Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.18, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг даргатай 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний 2 дугаар хавсралтын 9.4 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 318 тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”ын 2.1.5, 2.1.6, 3.1, Засаг даргын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Оросын Холбооны Улсын Буриад улсын нийслэл Улан-Үдэ хотод “Байгаль трэвел март 2019” аялал жуулчлалын үзэсгэлэнд Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадам, Хотод ойрхон говь нэгдсэн эвент арга хэмжээнүүдээ сурталчлан оролцсон үйл ажиллагаанд 909498 (Есөн зуун есөн мянга дөрвөн зуун ерэн найм)-н төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. “Байгаль трэвел март 2019” аялал жуулчлалын үзэсгэлэнд зарцуулагдах нийт 909498 (Есөн зуун есөн мянга дөрвөн зуун ерэн найм)-н төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488190542